



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/11-НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: О.Анхбаяр
Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Дотоод хяналт	13
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
4.4 Материаллаг байдал.....	14
5. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
5.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
5.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	15
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
8. Аудитын илрүүлэлт	16
8.2.1 Залруулсан алдаа	16
8.2.2 Албан шаардлага	17
8.2.3 Зөвлөмж.....	18
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХС	Аймаг хөгжүүлэх сан
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТОУС	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
ТАХ	Төрийн албан хаагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.15 № СЭА-2022/11-НА-СТА-ОНА
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- 2021 оны зорилтот түвшин, төлөвлөгөөг эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын эх үүсвэр, зардлын тооцоогоор нэг бүрчлэн төлөвлөж, холбогдох байгууллагаар батлуулаагүй,
- Нягтлан бодох бүртгэлийн журнал, дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөөгүй буюу нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг холбогдох дарааллын дагуу гүйцэтгээгүй зэргээр бүртгэлийн үйл ажиллагаанд санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг мөрдөөгүй,
- Төрийн албан хаагчтай байгуулсан орон сууц захиалгаар барих гэрээний үүргийн биелэлтийн дагуу төвлөрүүлэх орлогоос 5 албан хаагчийн 2,282.5 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн,

- 2009-2016 онуудад АХС-аас олгосон зээлээс эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх талаар хууль, хяналтын байгууллагуудад хандан шүүхийн шийдвэр гаргуулан ажиллах явцад хариуцагч нь нас барсан, гадаадад байгаа гэх 6 зээлдэгчийн **135,000.0** мянган төгрөгийн зээлийг хэрэгсэхгүй болгосон шийдвэр гарсныг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Эдгээр зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь “*Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх “*Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө*”, 4.1.1:” *Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт*”, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь “*Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ*, 14.3.1: *Анхан шатны баримт бүрдүүлэх*, 14.3.2: *Журналд бичих*, 14.3.3: *Дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх*, 14.3.4: *Ажил, гүйлгээний мэдээ гаргах*, 14.3.5: *Санхүүгийн тайлан гаргах*”, Төрийн албан хаагчтай байгуулсан “*Орон сууц захиалгаар барих*” гэрээний 2.2, Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “*Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар*”-ын 2.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Бусад мэдээлэл

Тайлант онд үйлдвэрийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдаагүй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1.1	Эргэлтийн хөрөнгө		
	МӨНГӨН ХӨРӨНГӨ	328,696,095.84	610,003,279.10
1.1.1	Арилжааны банк дахь харилцах	328,696,095.84	610,003,279.10
	АВЛАГА	2,761,117,986.38	6,041,210,909.51
1.1.2	Дансны авлага	38,801,977.50	4,275,177,346.63
1.1.3	Бусад авлага/ ажилчидтай холбогдсон авлага/	-	1,154,600.00
1.1.4	Бусад авлага/ байгууллагаас авах авлага/	1,961,488,317.00	1,156,262,660.00
1.1.5	Бусад авлага/ хувь хүнээс авах авлага/	760,827,691.88	608,616,302.88
	УРЬДЧИЛГАА	5,510,568,271.86	-
1.1.6	Урьдчилж төлсөн зардал/тооцоо/	5,510,568,271.86	-
1.1.7	Эргэлтийн хөрөнгийн дүн	8,600,382,354.08	6,651,214,188.61
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Машин тоног төхөөрөмж	2,799,999.00	2,799,999.00
1.2.2	Хуримтлагдсан элэгдэл	-1,026,666.80	-1,679,999.40
1.2.3	Тавилга эд хогшил	3,723,600.00	3,723,600.00
1.2.4	Хуримтлагдсан элэгдэл	-3,723,600.00	-3,723,600.00
1.2.5	Бусад эргэлтийн хөрөнгө	-	468,262,575.59
1.2.6	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,773,332.20	469,382,575.19
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,602,155,686.28	7,120,596,763.80
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	НДШ-ийн өглөг		82,316.58
2.1.1.2	Байгууллагад төлөх өглөг	2,600,697.00	-
2.1.1.3	Урьдчилж орсон орлого	2,874,827,421.67	-
2.1.1.4	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,877,428,118.67	82,316.58
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат өр төлбөр	1,200,000,000.00	650,000,000.00
2.1.2.5	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,200,000,000.00	650,000,000.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн		
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-Орон нутгийн сан	908,960.00	908,960.00
2.3.2	Өмч:-Төрийн	-	4,338,060,572.22
2.3.3	Хуримтлагдсан ашиг	4,581,585,272.87	4,523,818,607.61
2.3.4	Тайлант үеийн ашиг/алдагдал/	-57,766,665.26	-2,392,273,692.61
2.3.5	Эздийн өмчийн дүн	4,524,727,567.61	6,470,514,447.22
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	8,602,155,686.28	7,120,596,763.80

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	-
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг(алдагдал)	-	-
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	2,496,528.16	12,685,431.50
6	Бусад орлого /алдангийн орлого/	3,220,000.00	1,623,001,453.78
7	Бусад орлого /УТХА орлого бараа материал/	418,446,768.10	1,118,992,368.10
8	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
9	Ерөнхий ба удирдлагын зардал	34,560,095.34	40,047,223.86
10	Санхүүгийн зардал	5,738,300.00	25,898,090.23
11	Бусад зардал	441,631,566.18	5,081,007,631.90
12	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-57,766,665.26	-2,392,273,692.61
13	Орлогын татварын зардал	-	-
14	Татварын дараах ашиг (алдагдал)	-57,766,665.26	-2,392,273,692.61
15	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
16	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-57,766,665.26	-2,392,273,692.61

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	908,960.00	4,581,585,272.87	4,582,494,232.87
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-
Залруулсан үлдэгдэл	908,960.00	4,581,585,272.87	4,582,494,232.87
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(57,766,665.26)	(57,766,665.26)
Өмчид гарсан өөрчлөлт			-
Зарласан ногдол ашиг			-
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	908,960.00	4,523,818,607.61	4,524,727,567.61
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		(6,799,000.00)	(6,799,000.00)
Залруулсан үлдэгдэл	908,960.00	4,517,019,607.61	4,517,928,567.61
Өмчид гарсан өөрчлөлт	4,338,060,572.22		4,338,060,572.22
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(2,392,273,692.61)	(2,392,273,692.61)
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,338,969,532.22	2,131,544,915.00	6,470,514,447.22

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,791,666,905.16	785,299,248.05
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого/ТӨҮГ/	600,309,218.90	772,613,816.55
	Татаас санхүүжилтийн орлого	1,185,641,158.10	-
	Хүүгийн орлого	2,496,528.16	-
	Бусад мөнгөн орлого	3,220,000.00	12,685,431.50
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,601,715,526.69	67,286,373.29
	Ажиллагчдад төлсөн цалин	28,100,205.04	32,112,382.28
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	6,683,909.30	9,007,125.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	16,324,795.75	2,723,820.00
	Бичиг хэргийн зардал		
	Тээвэр шатахууны зардал	4,850,000.00	7,300,000.00
	шуудан холбооны зардал	-	-
	Дотоод албан томилолтын зардал		
	Татварын байгууллагад төлсөн	1,185,641,158.10	12,676,666.01
	Бусад мөнгөн зарлага	360,115,458.50	3,466,380.00
	Банкны үйлчилгээний хураамж		
	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр		
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	189,951,378.47	718,012,874.76
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	83,003,105.00	246,769,999.50
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	83,003,105.00	246,769,999.50
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	683,475,691.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	683,475,691.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	83,003,105.00	(436,705,619.50)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	272,954,483.47	281,307,183.26
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	55,741,612.37	328,696,095.84
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	328,696,095.84	610,003,279.10

2.4 Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	Нийт санхүүгийн эх үүсвэр	3,130,411,598.63	1,341,747,217.81	1,022,736,553.47	-319,010,664.34	76.22
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	55,741,612.37	328,696,095.84	0.00	-328,696,095.84	0.00
A	Нийт орлогын дүн	3,074,669,986.26	1,013,051,121.97	1,022,736,553.47	9,685,431.50	100.96
1	Үндсэн үйл ажиллагааны орлого	683,312,300.00	1,010,051,121.97	772,613,816.55	-237,437,305.42	76.49
2	Орон нутгийн төсвөөс өгсөн санхүүжилт	1,185,641,158.10	0.00	0.00	0.00	0.00
3	Зээлийн санхүүжилт	1,200,000,000.00	0.00	0.00	0.00	0.00
	Бусад орлого	5,716,528.16	3,000,000.00	12,685,431.50	9,685,431.50	422.85
Б	Нийт зардлын дүн	2,801,715,510.09	110,034,323.05	54,609,707.28	-55,424,615.77	49.63
1	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	0.00	0.00	0.00	0.00	0.00
2	б) Ерөнхий ба удирдлагын зардал	2,801,715,510.09	110,034,323.05	54,609,707.28	-55,424,615.77	49.63
3	Цалин хөлс урамшуулал	34,784,114.34	52,034,323.05	41,119,507.28	-10,914,815.77	79.02
4	Үндсэн цалин	28,100,205.04	46,252,731.60	32,112,382.28	-14,140,349.32	69.43
5	Ажил олгогчоос төлөх НДШ	6,683,909.30	5,781,591.45	9,007,125.00	3,225,533.55	155.79
6	Үр дүнгийн урамшуулал	0.00	0.00	0.00	0.00	0.00
7	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,766,931,395.75	58,000,000.00	13,490,200.00	-44,509,800.00	23.26
8	Бичиг хэрэг	888,300.00	1,500,000.00	1,240,820.00	-259,180.00	82.72
9	Тээвэр шатахуун	4,850,000.00	6,500,000.00	7,300,000.00	800,000.00	112.31
10	Сургалт семинарын зардал	0.00	200,000.00	0.00	-200,000.00	0.00
11	Шуудан холбооны зардал	0.00	200,000.00	0.00	-200,000.00	0.00
12	Дотоод албан томилолт	1,266,800.00	2,000,000.00	0.00	-2,000,000.00	0.00
13	Ном хэвлэл худалдан авах	20,000.00	100,000.00	0.00	-100,000.00	0.00
14	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	0.00	2,500,000.00	0.00	-2,500,000.00	0.00
15	Банкны үйлчилгээний хураамж	46,700.00	0.00	54,380.00	54,380.00	0.00
16	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	10,000,000.00	1,483,000.00	-8,517,000.00	14.83
17	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	15,416,495.75	35,000,000.00	3,412,000.00	-31,588,000.00	9.75
18	в) Хөрөнгө оруулалт их засвар	2,744,443,100.00	0.00	0.00	0.00	0.00
В	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	328,696,095.84	0.00	610,003,279.10	610,003,279.10	0.00

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Тус үйлдвэрийн газар нь “Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд геодез, зураг зүй, суурь судалгаа, газрын кадастр, мониторинг, газар зохион байгуулалт, хот байгуулалтын салбарын шинжлэх ухаан, технологийн талаарх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, иргэдийн амьдрах болон баялаг бүтээх эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж ажиллана” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөрөнгийн тогтвортой сан бүрдүүлэх,
- Төрийн өмнөөс аймгийн нутаг дэвсгэрт орон сууц бариулах ажлыг зохион байгуулах,
- Хөрөнгө оруулалтын менежментийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Иргэд, залуу гэр бүл болон төрийн албан хаагчдад орон сууцны зээлийн санхүүжилтийг хэрэгжүүлэх,
- Сумдын төрийн албан хаагчдыг орон сууцжуулах ажлыг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан эхлүүлэх,

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ыг аймгийн ИТХТ-ийн 2005 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор байгуулсан байна. Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйл “Аймаг, нийслэлийн Хурлын бүрэн эрх”, 19.1 дэх “Аймаг, нийслэлийн Хурал нь харьяалах нутаг дэвсгэртээ энэ хуулийн 18 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ **орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих**” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай,

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	328,696.1	610,003.3	281,307.2
Авлага	2,761,118.0	6,041,210.9	3,280,092.9
Урьдчилж төлсөн зардал	5,510,568.3	-	(5,510,568.3)
Бараа материал	-	-	-
Үндсэн хөрөнгө	1,773.3	469,382.5	467,609.2
Нийт хөрөнгө	8,602,155.7	7,120,596.7	(1,481,559.0)
Богино хугацаат өр төлбөр	2,600.7	82.3	(2,518.4)
Урьдчилж орсон орлого	2,874,827.4	-	(2,874,827.4)
Урт хугацаат өр төлбөр	1,200,000.0	650,000.0	(550,000.0)
Эздийн өмч	4,524,727.6	6,470,514.4	1,945,786.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,602,155.7	7,120,596.7	(1,481,559.0)

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урчилж гарсан зардал, өр төлбөр, урьдчилж орсон орлого дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 610,003.3 мянган төгрөг болж 281,307.2 мянган төгрөгөөр өссөн нь АХС-ийн авлагыг барагдуулсан болон ТАХ-ийн захиалгын байрны гэрээний дагуу төвлөрсөн орлогоос шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 6,041,210.9 мянган төгрөг болж 3,280,092.9 мянган төгрөгөөр өссөн нь ТАХ-ын 120 айлын орон сууцыг улсын комиссоор хүлээн авсантай холбоотойгоор зээлдэгчдээс авах 4,275,177.3 мянган төгрөгийн авлагыг шинээр үүсгэсэн, ажилчидтай холбогдсон цалингийн авлага 1,154.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн болон АХС-ийн зээлийн эргэн төлөлтийн хувь хүнээс авах авлага 152,211.4 мянган төгрөг, аж ахуйн нэгжээс авах авлага 805,225.6 мянган төгрөг, Зочу Сэлэнгэ ХХК-иас авах цементийн тооцооны авлага 38,802.0 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэлд 2009-2016 онуудад АХС-аас ЖДҮ-ийг дэмжих зорилгоор олгосон зээлийн эргэн төлөлтөөс шалтгаалан үүссэн хувь хүнээс авах 608,616.3 мянган төгрөг, аж ахуйн нэгжээс авах 1,156,262.6 мянган төгрөг зэрэг нийт 1,764,878.9 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Урьдчилж төлсөн зардал данс үлдэгдэлгүй тайлагнагдаж, 5,510,568.3 мянган төгрөгөөр буурсан нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2018 оны А/449 дугаар захирамжаар байгуулагдсан барилга байгууламж ашиглалтад оруулах комиссын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн БУ-12/2021 тоот дүгнэлтээр “ТАХ-ийн 120 айлын орон сууц”-ны барилга угсралтын ажлыг ашиглалтад хүлээн авч урьдчилж

гарсан зардлын 5,510,568.3 мянган төгрөгийг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс /анхны өртгөөр/ 474,786.2 мянган төгрөг болж 468,262.6 мянган төгрөгөөр өссөн нь ТАХ-ийн 120 айлын орон сууцны борлуулагдаагүй 468,262.6 мянган төгрөгийн орон сууцыг дуусаагүй барилгад бүртгэсэнтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөрийн дансны үлдэгдэл 82.3 мянган төгрөг болж 2,518.4 мянган төгрөгөөр буурсан нь “Таванхан Уул” ХХК-иар гүйцэтгүүлсэн ажлын дутуу төлбөр 2,600.7 мянган төгрөгөөр барагдсан, нийгмийн даатгалын шимтгэлийн 82.3 мянган төгрөгийн өглөг үүссэнтэй холбоотой байна.

Урьдчилж орсон орлого данс үлдэгдэлгүй болж 2,874,827.4 мянган төгрөгөөр буурсан нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2018 оны А/449 дүгээр захирамжаар байгуулагдсан барилга байгууламж ашиглалтад оруулах комиссын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн БУ-12/2021 тоот дүгнэлтээр “ТАХ-ийн 120 айлын орон сууц”-ны барилга угсралтын ажлыг ашиглалтад хүлээн авч урьдчилж орсон орлогын 2,874,827.4 мянган төгрөгийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 650,000.0 мянган төгрөг болж 550,000.0 мянган төгрөгөөр буурсан нь 2019 онд “Бүрнээ Мөнхбат” ХХК, “Таванхан Уул” ХХК, “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын байгуулсан гуравласан гэрээний дагуу 550,000 мянган төгрөгийг төлж барагдуулсантай холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 6,470,514.4 мянган төгрөг болж 1,481,559.0 мянган төгрөгөөр өссөн нь ТАХ-ийн орон сууцыг улсын комиссоор хүлээн авсантай холбоотой өмч 4,338,060.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн болон тайлант оны алдагдал 2,392,273.7 мянган төгрөг гарснаас шалтгаалжээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

2019 онд боловсруулан баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үйлдвэрлэлийн өртгийн тайлан гаргах, насжилт өндөртэй найдваргүй авлагын бүртгэл, өр төлбөрийн бүртгэл, борлуулалтын орлого, борлогдсон бүтээгдэхүүний өртөг тооцох бодлого горимыг тодорхой тусгаагүй, СТОУС-11-д заасан барилгын гэрээний стандарт, СТОУС-15-д заасан “Худалдан авагчтай байгуулсан гэрээний орлогын стандарт”, Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”, Сангийн сайдын 2016 оны 410 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын гэрээний орлого ба зардлын нягтлан бодох бүртгэлийн стандарт”-тай тус тус нийцээгүй байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-нь 2021 оны орлого, зарлагын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/22 дугаар захирамжаар батлуулсан байна.

Гүйцэтгэлээр 2,754,679.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 5,146,952.9 мянган төгрөгийн зардал гарган, 2,392,273.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ орон сууц ОНӨААТҮГ /цаашид “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ гэх/-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд гэрээний хэрэгжилт, авлагын данс, төлбөрийн цахим баримттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Үйлдвэрийн газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө муутай гэж дүгнэж байна.

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын хувьд дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтангүй бөгөөд тайлант жилийн хугацаанд аймгийн ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт, шалгалт хийгдээгүй байна.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс

үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт авлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “**дунд**” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт авлага 6,041,210.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 60,412.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу **42,288.5** мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

- АХС-аас 2009-2016 оны хугацаанд олгосон зээлээс томоохон 4 аж ахуйн нэгжид олгосон зээлийн авлагын 2021 оны эхний үлдэгдэл 1,479,040.4 мянган төгрөг байснаас “Гурван тулгат цамхаг” ХХК-ийн 480,000.0 мянган төгрөгийн зээлийн үлдэгдлийг ТАХ-ийн 120 айлын барилгын ажлын гүйцэтгэгч “Таван хан Уул” ХХК-ийн 2021.08.13-ны өдрийн 21/89 тоот албан бичгийг үндэслэн тус байгууллагад олгох гүйцэтгэлийн санхүүжилтийн дүнгээс хасаж тооцоноос Гурван тулгат цамхаг” ХХК-иас авах авлага бүрэн барагдсан байна. Алтанбилэг ХХК-иас авах авлагын 2021 оны эхний үлдэгдэл 224,000.0 мянган төгрөг байснаас тус газрын барьсан 3 орон сууцыг зээлийн төлбөрт шилжүүлэн тооцон Алтанбулаг сумын 3 төрийн албан хаагчтай гэрээ байгуулан оруулснаас тус компанийн авлага хаагдсан байна. Харин “Ганмон Энжелс” ХХК нь оны эхэнд 720,000.0 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаагаас 634,363.0 мянган төгрөгийн зээлийн төлбөрт тооцон Цагааннуур, Ерөө, Баянгол, Шаамар сумдад 13 орон сууц, 4 автомашины зогсоолыг шилжүүлэн тооцохоор 172,246.5 мянган төгрөгийг бэлнээр төлөхөөр/ зэрүү нь алданги Сэлэнгэ аймгийн ИТХТ-ийн 2021 оны 39 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн байна. Цаашид шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авах, шаардлагатай бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандаж авлагыг барагдуулах нь зүйтэй юм.
- Нийслэл хүнс ХХК нь 2009 онд 300,000.0 мянган төгрөгийн зээл авснаас тайлант оны байдлаар 72,800.0 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. 2018-2020 онуудад зээлийн эргэн төлөлтийг тогтмол хийж байсан боловч тайлант онд Ковид-19 цар тахлын үеэр үйл ажиллагаа тасалдсан гэх шалтгаанаар зээлийн эргэн төлөлт хийгээгүй байна.

- Дээрх 4 аж ахуйн нэгжээс гадна **61** иргэн, аж ахуйн нэгж зээлийн үлдэгдэлтэй байгаагаас ШШГГ-ын гүйцэтгэх ажиллагаанд 42 зээлдэгч, нас барсан 4 зээлдэгч, шүүхээр эвлэрлийн гэрээ байгуулсан 5 зээлдэгч, эрэн сурвалжилж байгаа 1 зээлдэгч, гадаадад байгаа 2 зээлдэгч, шүүхийн шатанд байгаа 7 зээлдэгч байна.

5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын мэдээлбэл зохих 18 төрлийн 148 мэдээллээс 38 мэдээллийг хугацаанд нь, **110** мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

5.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д “*Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;*” гэж заасны дагуу Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинг тооцоогүй санхүүгийн төлөвлөгөөг батлуулаагүй байна.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 918.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 53,786.6 мянган төгрөгийн 2 албан шаардлагыг биелүүлж, 2 албан шаардлагыг биелүүлээгүй байна. Аудитаар өгсөн 2 зөвлөмж хэрэгжээгүй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	918.1	1	918.1	100.0
Албан шаардлага	4	53,786.6	2	53,786.6	50.0
Зөвлөмж	2	150,000.0	1	-	50.0
Нийт дүн	7	204,704.7	3	54,704.7	42.8

Өмнөх аудитаар өгсөн нягтлан бодох бүртгэлийн журнал, дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөөгүй, шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зэрэг зөрчлийг арилгах албан шаардлага, найдваргүй авлагыг данс бүртгэлээс хасах зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1-т “...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу нягтлан бодогч З. Загдсүрэнд сахилгын шийтгэл ногдуулах **албан шаардлага** хүргүүлэхээр, хэрэгжээгүй зөвлөмжид албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,882,897.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 4,743,440.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 137,282.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 2,174.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

8.2.1 Залруулсан алдаа

- ТАХ-ийн 120 айлын орон сууцыг улсын комиссоор хүлээн авсантай холбоотойгоор үүсэх дансны авлагыг 4,073,937.0 мянган төгрөгөөр, дуусаагүй барилга, байгууламжийг 468,262.6 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн зэрэг нийт **4,542,199.6** мянган төгрөгийг санхүүгийн байдлын тайлан, үндсэн хөрөнгийн тодруулгад залруулга хийв.
- Алтанбилэг ХХК-иас 2 өрөө орон сууц 2 ширхэг, 3 өрөө орон сууц 1 ширхгийг 224,000.0 мянган төгрөгийн зээлийн төлбөрт шилжүүлэн тооцон Алтанбулаг сумын 3 албан хаагчид гэрээ байгуулан олгосон боловч тэдгээрээс авах **201,240.4** мянган төгрөгийн зээлийн авлагыг тусгаагүйг санхүүгийн байдлын тайлан болон авлагын тодруулгад залруулав.

8.2.2 Албан шаардлага

1. Төрийн албан хаагчтай байгуулсан орон сууц захиалгаар барих гэрээний үүргийн биелэлтийн дагуу төвлөрүүлэх орлогоос **5** албан хаагчийн **2,282.5** мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн Төрийн албан хаагчтай байгуулсан “Орон сууц захиалгаар барих” гэрээний 2.2 дахь “Захиалагч нь үл хөдлөх эд хөрөнгийн төлбөрийг энэхүү гэрээнд заасан хуваарийн дагуу төлнө” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний үүргийг биелэлтийг хангуулах албан шаардлага хүргүүлэх.

2. “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ нь 2021 оны зорилтот түвшин, төлөвлөгөөг эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын эх үүсвэр, зардлын тооцоогоор нэг бүрчлэн төлөвлөөгүй, зөвхөн урсгал үйл ажиллагааны зардлаар тооцон боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь “*Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах*” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвхөн урсгал үйл ажиллагааны зардлын бус үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах албан шаардлага хүргүүлэх.

3. Нягтлан бодох бүртгэлийн журнал, дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөөгүй буюу нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг холбогдох дарааллын дагуу гүйцэтгээгүй зэргээр бүртгэлийн үйл ажиллагаанд санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг мөрдөөгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх “*Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө*”, 4.1.1: “*Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт*”, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь “*Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ*, 14.3.1: *Анхан шатны баримт бүрдүүлэх*, 14.3.2: *Журналд бичих*, 14.3.3: *Дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх*, 14.3.4: *Ажил, гүйлгээний мэдээ гаргах*, 14.3.5: *Санхүүгийн тайлан гаргах*” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд программ ашиглах замаар нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу, холбогдох дарааллаар хөтлөх албан шаардлага хүргүүлэх.

4. 2009-2016 онуудад АХС-аас олгосон зээлээс эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх талаар хууль, хяналтын байгууллагуудад хандан шүүхийн шийдвэр гаргуулан ажиллах явцад хариуцагч нь нас барсан, гадаадад байгаа гэх 6 зээлдэгчийн **135,000.0** мянган төгрөгийн зээлийг хэрэгсэхгүй болгосон шийдвэр гарсан боловч шийдвэрийн дагуу арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Аж ахуйн

нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын 2.1 дэх “*Найдваргүй авлагын шууд арга буюу үл цуглуулагдах хэмжээгээр шууд хөрөнгийн данснаас зардлын дансанд шилжүүлдэг, өөрөөр хэлбэл өр эзэмшигч хуулийн этгээд, дампуурсан, төлбөрийн чадваргүй гэж зарлагдсан, татан буугдсан зэрэг тохиолдолд тухайн иргэн, байгууллагаас авах авлагыг найдваргүй гэж тооцон ...*” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Найдваргүй авлагыг данс бүртгэлээс хасах арга хэмжээ авч, авлагын дансны үлдэгдлийг бодитоор тайлагнах.

8.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримт, төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

1.1. **Илрүүлэлт:** Тайлант онд **2,174.9** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2. **Өгсөн зөвлөмж:** Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй*” гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ*” гэж заасныг зөрчсөн ба “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:										
						Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	"Сэлэнгэ орон сууц" ОНӨААТҮГ	СЭА-2022/11-НА-СТА-ОНА	ТАХ-ын 120 айлын орон сууцыг улсын комиссоор хүлээн авсантай холбоотойгоор үүсэх дансны авлага, дуусаагүй барилга, байгууламжийг дутуу илэрхийлсэн,	1	4,542,199.6	1	4,542,199.6									
2			Алтанбилэг ХХК-иас зээлийн төлбөрт шилжүүлэн тооцсон орон сууцыг Алтанбулаг сумын 3 албан хаагчид гэрээ байгуулан олгосон боловч тэдгээрээс авах зээлийн авлагыг тусгаагүй	1	201,240.4	1	201,240.4									
3			Гэрээний үүргийн биелэлтийн дагуу төвлөрүүлэх орлогыг дутуу төвлөрүүлсэн,	1	2,282.5					1	2,282.5					
4			Зорилтот түвшин, төлөвлөгөөг эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын эх үүсвэр, зардлын тооцоогоор нэг бүрчлэн төлөвлөөгүй,	1	-					1	-					
5			Нягтлан бодох бүртгэлийн журнал, дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөөгүй,	1	-					1	-					
6			Найдваргүй авлагыг данс бүртгэлээс хасаагүй,	1	135,000.0					1	135,000.0					

7			Бараа материалын худалдан авалтыг төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.	1	2,174.9								1	2,174.9	
8			Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан	1	-							1	-		
ДҮН				8	4,882,897.4	2	4,743,440.0			4	137,282.5	1	-	1	2,174.9
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал															
9	“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ	СЭА-2022/11-НА-СТА-ОНА	Шилэн дансанд мэдээлбэл зохих 148 мэдээллээс 110 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.	1	-								1		
ДҮН				1											
НИЙТ ДҮН				9	4,882,897.4	2	4,743,440.0			4	137,282.5	2	-	1	2,174.9